



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Матад сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2024/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2024 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatarsu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 316

танай _____-ны № _____-т

МАТАД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Матад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Матад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Матад сумын Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл нийт 16.6 сая төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Матад сумын 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын ИТХ-ын 2023 оны 22 дугаар тогтоолоор "хангалттай" гэж үнэлж дүгнэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011021204

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,281,799.4</u>	<u>1,866,379.4</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	825,065.0	1,310,648.7
33	АВЛАГА	328,951.6	328,951.6
35	БАРАА МАТЕРИАЛ	127,782.8	226,779.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,769,628.4</u>	<u>5,031,053.6</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,769,628.4	5,031,053.6
392	Биет хөрөнгө	3,732,592.6	4,948,083.2
393	Биет бус хөрөнгө	37,035.8	82,970.4
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,051,427.8</u>	<u>6,897,433.0</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,051,427.8</u>	<u>6,897,433.0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,051,427.8	6,897,433.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	850,811.8	897,109.8
512	Хуримтлагдсан үр дүн	3,906,466.8	5,706,174.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	294,149.2	294,149.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,051,427.8</u>	<u>6,897,433.0</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,794,215.9	4,644,432.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,196,525.9	1,838,599.4
110	Орлогын албан татвар	1,168,181.1	1,555,232.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,178,014.6	1,565,229.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,833.5)	(9,996.5)
113	Хөрөнгийн албан татвар	8,416.4	175,114.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	19,928.4	108,251.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,928.4	108,251.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,366,094.1	1,763,282.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,141,094.1	1,553,282.7
122	Тусламжийн орлого	225,000.0	210,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,231,595.9	1,042,550.2
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,638,393.3	1,791,408.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,638,393.3	1,791,408.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,041,690.0	1,385,299.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,567.8	590,696.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,560.4	72,959.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,052.5	50,934.0
2104	Хангамж, бараа материалын зардал	47,103.2	52,597.7
2105	Нормативт зардал	1,418.5	556.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,666.5	11,950.7
2107	Томилолт, зочны зардал	8,232.4	26,188.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,273.6	98,744.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	330,815.1	480,673.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,596,703.3	406,109.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,155,822.6</u>	<u>2,853,023.8</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,527,893.6	1,053,316.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(2,372,071.0)</u>	<u>1,799,707.2</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,861,366.0</u>	<u>3,191,124.4</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,196,525.9	1,838,599.4
110	Орлогын албан татвар	1,168,181.1	1,555,232.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,178,014.6	1,565,229.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,833.5)	(9,996.5)
113	Хөрөнгийн албан татвар	8,416.4	175,114.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	19,928.4	108,251.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,448.8	967.4
1181	Газрын төлбөр	16,024.9	104,508.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,454.7	2,776.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	433,244.2	309,974.8
120	Нийтлэг татварын бус орлого	208,244.2	99,974.8
122	Тусламжийн орлого	225,000.0	210,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,231,595.9	1,042,550.2
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,423,589.0</u>	<u>1,478,286.8</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,423,589.0	1,478,286.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826,885.7	1,096,924.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,567.8	590,696.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,560.4	72,959.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,191.9	51,819.5
2104	Хангамж, бараа материалын зардал	40,442.0	47,517.2
2105	Нормативт зардал	697.0	840.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,867.6	11,746.3
2107	Томилолт, зочны зардал	8,232.4	26,188.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,278.4	123,490.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,048.2	171,666.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,596,703.3	381,362.8

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,437,777.0</u>	<u>1,712,837.6</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,127,658.9	1,177,253.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,127,658.9	1,177,253.9
2200	Дотоод эх үүсвэрээр	1,127,658.9	1,177,253.9
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,127,658.9)</u>	<u>(1,177,253.9)</u>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	50,000.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(100,000.0)</u>	<u>(50,000.0)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	210,118.1	485,583.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	614,946.8	825,065.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	825,065.0	1,310,648.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,376,418.3	740,422.8	3,766,211.9	6,883,053.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,525,606.4	-446,273.5	2,512,325.7	540,445.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	850,811.9	294,149.3	6,278,537.6	7,423,498.8
C07	Тайлант үеийн үр дүн			-2,372,071.0	-2,372,071.0
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	850,811.9	294,149.3	3,906,466.6	5,051,427.8
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	850,811.9	294,149.3	3,906,466.6	5,051,427.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	850,811.9	294,149.3	3,906,466.6	5,051,427.8
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	46,298.0	0.0	0.0	46,298.0
D08	Тайлант үеийн үр дүн			1,799,707.1	1,799,707.1

D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,109.9	294,149.3	5,706,173.7	6,897,432.9
-----	---------------------------------------	-----------	-----------	-------------	-------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11210.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11210.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11210.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	712.0
210104	Урамшуулал	712.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5890.4
210402	Тээвэр, шатахуун	5890.4
2105	Нормативт зардал	340.0
210502	Хоол, хүнс	340.0
2107	Томилолт, зочны зардал	1498.5
210702	Дотоод албан томилолт	1498.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2770.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2770.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11210.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11210.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11048.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	162.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 135.9 сая төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, 135.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 АЛБАН ШААРДЛАГА

1. Матад сумын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтад зураг төсвөө батлуулаагүй 495.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн төвлөрсөн халаалт" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж батлуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:", 13.3.3-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2. Шилэн дансны цахим хуудсанд төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 18 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ил тод мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

5.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Орлогын төлөвлөлт

Илрүүлэлт:

Тайлант онд малын татварын төлөвлөгөөг 232.9 сая төгрөгөөр тооцож төлөвлөснийг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тооцоход тухайн оны малын тоо толгойн татварыг 135.9 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Малын татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж батлуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Матад сумын ТТЗ	2	135.9			1	0	1	135.9				
Дүн	2	135.9			1	0	1	135.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Матад сумын ТТЗ	1	0	-	-	1	0	-	-
Дүн	1	0	-	-	1	0	-	-